



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 онд 12 сарын 08 одор

Дугаар 1/439

Улаанбаатар хот


Гэрээний хугацааг сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2021 оны 264 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”, Боловсролын зээлийн сангийн “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад буцалтгүй тусламж олгох тухай гэрээ”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын хамтарсан санхүүжилттэй Засгийн газрын тэтгэлгээр бакалаврын шатлалд суралцаж буй Түвшин овогтой Өлзийхишиг, Бадам овогтой Энхжаргал, Гансэлэм овогтой Ганцацрал, докторын шатлалд суралцаж буй Дашибалдан овогтой Соёл, Ганбаатар овогтой Одбаяр, Сүхбат овогтой Отгонсүрэн нарын гэрээний хугацааг нэг жилтээр, магистрын шатлалд суралцаж буй Халтар овогтой Дэлгэрцэцэгийн гэрээний хугацааг нэг хичээлийн улирлаар тус тус сунгахыг Боловсролын зээлийн сан /Ж.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.
2. Иргэдтэй зохих журмын дагуу гэрээг сунгаж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /Ж.Ариунболд/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар /Ш.Нарантуяа/-т тус тус даалгасугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН



142111581